

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2015 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ

2015 оны 12 дугаар сарын 30

№	Сургалтын сэдэв	Шаардлагатай төсөв	Биелэлт
1	Дотоод аудит, шилэн дансны сургалт	Шаардлагагүй	СЯ-ны дотоод аудитын тусгайлсан 2 өдрийн сургалтад дарга Д.Нацагдорж, САХ-н дарга Д.Үүрийнтуяа, ГАХ-ийн шинжээч Н.Нарангэрэл нар суусан. Интерактив ХХК, НМТГ-аас зохион байгуулсан нийслэлийн Шилэн дансны системийн сургалтад нийслэл, дүүргийн 32 аудитор, шинжээчид оролцсон Интерактив ХХК, НМТГ-аас зохион байгуулсан нийслэлийн Шилэн дансны системийн сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан. СЯ-ны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэстэй хамтран “Дотоод аудитын ажлын баримтыг хэрхэн сайн хөтлөх вэ” үзүүлэх сургалтыг яамд, нийслэл, дүүргийн дотоод аудитын 100 орчим албан хаагчдын дунд зохион байгуулсан.
2	НЗДТГ болон харьяа байгууллагуудаас зохион байгуулах сургалтууд	Шаардлагагүй	НЗДТГ-ын хүний нөөцийн ажилтнуудад зориулсан "Байгууллагын хүний нөөцийн сэтгэл зүйн асуудал" сургалтад ЗХХ-н дарга Я.Сарансүх, “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй eoffice.ulaanbaatar.mn домайн нэр бүхий Э-Оффис системийн админы сургалтад Мэдээллийн технологи хариуцсан шинжээч С.Болор-Эрдэнэ 2 удаа суусан. Аудитор Б.Уранбилэг нь Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан нийслэл, дүүрэг, хороодын нутгийн захиргааны байгууллагын биеийн тамир спортын хамтлагийн "Эрүүл орчин-Эрүүл амьдралын хэв маяг" сэдэвт сургалтад 4 сарын 2,3-ны өдрүүдэд хамрагдсан
3	Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт	Шаардлагагүй	Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад дотоод ажил хариуцсан шинжээч Б.Солонгожаргал 2 удаа хамрагдаж, архивчийн мэргэжлийн гэрчилгээ авсан. Нийслэлийн Архивын газрын зөвлөмжийн дагуу нийт ажилтан, албан хаагчдад "Баримт бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд стандартыг оновчтой мөрдөх нь", "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт" зэрэг 4 удаагийн болон Монгол хэлний зөвлөлөөс журамласан 700 үг"-ийн сургалт явуулсан.
4	Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авах болон сунгах шалгалт	250,000.00	САХ-ийн аудитор Д.Лувсанчимэд мэргэшсэн нягтлан бодогчийн 5 жилийн эрх сунгах сургалтад хамрагдаж шалгалт өгч тэнцсэн. ГАХ-ийн шинжээч Н.Нарангэрэл, Б.Мягмарзаяа, Ня-бо Б.Сэргэлэн, шинжээч Б.Отгонцэрэн нар мэргэшсэн нягтлан бодогчийн сорил шалгалтууд өгч тэнцэж батламж авсан.

5	Хуульчийн үргэлжилсэн сургалт	50,000.00	Хуульчийн үргэлжилсэн сургалтын 2015 оны хөтөлбөрийн сонгосон сургалтуудад хууль, эрхзүйн хариуцсан албан хаагч хамрагдсан.
6	Гадаад орны дотоод аудитын байгууллагын үйл ажиллагааны сайн туршлагаас суралцах	Тодорхойгүй	<ul style="list-style-type: none"> <li>• Гадаад оронд болох сургалт, семинарт оролцох хүсэлтээ Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс, Төсөл, хамтын ажиллагааны хэлтэст удаа дараа тавьсан. СЯ-ны Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс санал болгосон Словен улсын Center of Excellence in Finance байгууллагын сургалтад аудитор, шинжээчдээ ирэх онд хамруулахаар судалж байна.</li> <li>• “ИБУИНВУ-ын улсын секторын дотоод аудитын стандарт”, “Малайзын улсын секторын дотоод аудитын үр ашигтай байдал” гэсэн бичиг баримтуудыг цахим хуудаснаас татан авч танилцан, өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж болох туршлагыг судалж байна.</li> <li>• Байгууллагын дарга Д.Нацагдорж, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Б.Эрдэнэсүрэн нар АНУ дахь Дотоод аудитын институтын гишүүнээр элссэн. • Энэтхэгийн ЗГ-ын эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны “Нийгмийн хөгжлийн сургалтын хөтөлбөр”-т хамрагдахыг хүссэн, болзол шаардлагыг хангасан 8 албан хаагчийн материалыг хургуулсан.</li> </ul>
8	Мэргэжлийн англи хэлний сургалт	5,600,000.00	“Цагаан эргийн цахиур” ХХК-ийн мэргэжлийн англи хэлний сургалтад 2015.06.02-26-нд 7 албан хаагч хамрагдаж, 1,540,000.00 төгрөг зарцуулсан.
9	Компанийн засаглалын сургалт	4,200,000.00	Аудит хийхтэй холбоотойгоор мэргэжлийн зайлшгүй шаардлагын хувьд Улсын Секторын Санхүү бүртгэлийн Институтаас сургалт авсан. Нийт 20 хүн хамрагдсан.
11	Бусад	270,000.0	Байгууллагын архивын ажилтаныг мэргэшүүлэх болон архивын улсын үзлэгт бэлтгэх зорилгоор Б.Солонгожаргалыг архивын мэргэжлийн сургалтанд хамруулж мэргэжлийн сертификат олгосон.
		125,000.0	Тасралтгүй боловсролын хүрээнд САХ-ийн ахлах аудитор Д.Лувсанчимэд ММНБИнститутын сургалтанд суусан.
Бүгд дүн		10,495,000.00	

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
Захиргаа, хуулийн хэлтсийн дарга

Я.Сарансүх